

БНХАУ-ЫН ҮНДЭСТНИЙ БОДЛОГЫН ШИНЭЧЛЭЛИЙН АСУУДАЛД

*Ч.Батцэцэг**

БНХАУ өөрчлөлт шинэчлэлийнхээ хүрээнд улс төрийн тэнцвэртэй бодлого, эдийн засгийн хөгжлийн бодлого, соёл, боловсрол, төлөвлөгөөт төрөлтийн бодлого, нийгмийн тогтвортой байдал, хууль зүйн баталгааг зохицуулах үүднээс үндэстний бодлого хэрэгжүүлж, үндэстний цөөнх болон үндэстний бүс нутгийн асуудалтай холбогдсон бүхий л хууль тогтоомж, дүрэм журмыг шинэчлэн засч залруулах ажлыг амжилттай гүйцэтгэж байна. Үүний үндсэн дээр социалист ардчилсан улс төрийн шинэчлэлээ эрчимжүүлэх, нийгмийн байдлыг дээд хэмжээнд тогтворжуулах, хууль зүйн тогтолцоог боловсронгуй болгон баталгаажуулах ажлыг чухалчилж байна.

Хятад улсад өнөөдөр хэрэгжиж буй үндэстний бодлогын үндсэн агуулга нь олон шат дараалал, шинжлэх ухааны тогтолцоо бүхий үндсэн бодлого болон тодорхой бодлогоос бүрддэг ажээ. Үндсэн бодлогыг хэрэгжүүлэхдээ улс төрийн чиг шугамыг удирдлага болгож, үндэстний тодорхой бодлогыг шийдвэрлэхэд удирдах үүрэг гүйцэтгэх аж. Тодорхой бодлогын хувьд аливаа нэг нутаг дэвсгэрт, зарим нэг талаас нь ажлыг ямар нэгэн зүйл ангиар шийдвэрлэх хүртэл удирдан явуулах, тодорхой ямар ажил зохион байгуулах, чухам яагаад зайлшгүй хэрэгжүүлэх гэх зэргээр үндсэн бодлогоо тодорхойлон гаргаж өгдөг байна. Чухам эндээс улс төрийн тэнцвэртэй бодлого, эдийн засгийн хөгжлийн бодлого, боловсролын бодлого, нийгмийн баталгааг хангах бодлого зэрэг олон төрөл, салбарын бодлогод үндсэндээ хуваагддаг гэж хэлж болно. Салбарын бодлогын гол чухал зүйлд тодорхой бодлого, бас зарим нэг үндсэн бодлого багтдаг байна.¹

Хятадын үндэстний бодлого ерөнхийдөө үндэстнийхээ тэгш эрхийг хангах, үндэстний эв нэгдлийг бэхжүүлэх, үндэстэн бүр нийтээрээ цэцэглэн хөгжихөд түлхэц болдог хэмээн үздэг. Үндэстний тэгш эрх болон үндэстний эв нэгдэл нь үндэстний онолын үндсэн цөм агаад хятадын үндэстний бодлогын тулгуур болдог. Харин үндэстэн бүр нийтээрээ цэцэглэн хөгжих гэдэг нь хятадын үндэстний бодлогыг хэрэгжүүлэх зорилго, хятадын социалист үндэстний бодлогын үндсэн зарчмын илэрхийлэл ажээ.

Бүтээн байгуулалтын явцад орчин үетэйгээ нийцсэн үндэстний бодлогыг бий болгох чухал асуудал тавигдаж, шийдвэрлэвэл зохих

* Ч.Батцэцэг-ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D)

тодорхой зүйлүүд улам ихээр нэмэгдэх болж, үндэстний бодлогыг бүхэлд нь сайжруулах алхам хийгдэж байна. Үүнд: үндэстний цөөнхид тохирсон өвөрмөц онцлогтой бодлого сонгон шалгаруулах, бодлого зохицуулалтын арга хэлбэрийг өөрчлөн уян хатан болгох, засаг захиргааны аргыг улам нарийвчилсан хэлбэрээр үргэлжлүүлэхээс гадна зах зээлийн эдийн засаг руу анхаарлаа түлхүү хандуулах, мөнгөний эргэлтийг сайжруулах зэрэг маш олон янз, төрөл зүйлийн арга хэлбэрийг чухалчлан авч үзэх ёстой болжээ. Мөн үндэстний бодлоготой холбогдсон олон хэлбэрийн үйл ажиллагаа бодит амьдралаас урган гарч ирснийг дурьдвал, төлөвлөгөөт төрөлтийн бодлого үндэстний цөөнхид харилцан адилгүй байх, тэдгээрийн оршин суух нутаг дэвсгэрт маш их ялгаатай байх гэх мэт.

БНХАУ-ын Үндэстний бодлогын үндсэн агуулгад үндэстний тэгш эрхийг хангах, үндэстний эв нэгдлийг бэхжүүлэх, үндэстний бүс нутгийн өөртөө засах хууль дүрмийн тухайд, үндэстний цөөнхийн газар нутгийн эдийн засаг, соёлын хөгжлийн талаар, үндэстний цөөнхийн боловсон хүчнийг сургаж хүмүүжүүлэх, үндэстний цөөнхийн бичиг үсэг, хэл, соёлыг хөгжүүлж хүндэтгэх, үндэстний цөөнхийн зан үйл, ёс заншлыг хүндэтгэх, үндэстний цөөнхийн шашин шүтлэг, сүсэг бишрэлийг хүндэтгэх зэрэг асуудал багтжээ. БНХАУ-ын Үндэстний бодлогын үндсэн агуулгад үндэстний хүн амын олон, цөөн, эдийн засаг, нийгмийн хөгжлийн ялгаа, зан заншил харилцан адилгүйгээс үл хамааран, хууль дүрэмд тулгуурлан харилцан ашигтай байх, харилцан адил үүрэг гүйцэтгэх ёстой гэжээ. Тухайлбал: Үндэстний тэгш эрхтэй байх хуульд ерөнхийд нь Хятад улсад ашигтай байх, үндэстэн бүр тухайн нутаг орондоо аж төрөх, ажил хөдөлмөр эрхлэх, аливаа үйл ажиллагаанд тэгш эрхтэй оролцох, эмчлүүлэх, эдийн засгаа хөгжүүлэх, боловсрох, шинжлэх ухаан, соёлын үйлст тэгш эрхтэй оролцох зэрэг багтах ба аливаа нэг үндэстний дарамтанд байх ёсгүйг заажээ.

Үндэстний эв нэгдэл нь улсын тогтвортой байдлын үндэс суурь болж аливаа үйл хэргийг даван туулах баталгаа болно. Үндэстний эв нэгдлийн үндсэн гол агуулга нь ах дүүгийн барилдлагатай байх явдал юм байна. Хятад улсын үндэстний эв нэгдэл гэдэг нь оюун санаа, соёл иргэншлийн бүтээн байгуулалт, эх орноо хайрлах үзлээр сурч хүмүүжихийг чухалчилдаг. Их хань үндэстний үзэл болон орон нутгийн үндэстний үзлийг эсэргүүцэн, үндэстнийг хагалан бутаргах, үндэстний эв нэгдлийг бусниулах, өдөөн хатгахыг хориглодог ба хань үндэстэн, цөөнх үндэстэн салшгүй гэсэн үзэл санааг баримталдаг. Үндэстний салан тусгаарлах хөдөлгөөнд хууль эрхийн дагуу хандаж үйл ажиллагаа явуулах тухай заасан байна.

Үндэстний бүс нутгийн өөртөө засах дүрэм нь нам, улсаас шийдвэрлэх үндэстний асуудлын үндсэн бодлого болдог. Улмаар улсын үндэс суурь, чиг шугамын баталгаа болж үндэстний цөөнхийн оршин суугаа газар нутагт үндэстний бүс нутгийн өөртөө засах дүрмийг хэрэгжүүлэх нь улсаас өөртөө засах дотоод үйл хэргийн бүрэн эрхийг бүрэн хүндэтгэж, үндэстэн бүрийн ард түмний идэвхи санаачлагыг дэмжин хөгжүүлж, үндэстний бүс нутгийн өөртөө засах эрхийг сайжруулах явдал мөн² гэдгийг онцолсон байна.

2005 онд “Хятадын үндэстний бүс нутгийн өөртөө засах” тухай анхны цагаан ном хэвлэгдсэн юм. Уг номд “БНХАУ үндэстний бүс нутгийн өөртөө засах байгууллыг хэрэгжүүлэхийг төрийн үндсэн бодлого болгохоор тодорхойлсон явдал бол Хятадын тодорхой байдалд суурилуулан боловсруулсан “түүхийн томоохон чухал сонголт боллоо”³ гэж тэмдэглэжээ. 2003 оны эцэс гэхэд Хятадад үндэстний өөртөө засах засаг захиргааны 155 нэгж байгуулагдсан байна. Үндэстний өөртөө засах засаг захиргаа бүхий нутаг дэвсгэр нь бүх Хятадын нийт нутаг дэвсгэрийн 64%-ийг эзэлдэг. Тэдгээр нь гол төлөв Хятадын нийт нутаг дэвсгэрийн баруун хойд, урд хэсэгт, зүүн хойд хязгаар нутаг, өмнөд мужуудад төвлөрдөг байна. Үндэстний өөртөө засах байгуулал үүсээр 50 гаруй жил болжээ. Үндэстний бүс нутгийн өөртөө засах байгуулал нь Хятадын улс төрийн үндсэн байгуулал болсны хувьд тасралтгүй хөгжиж байгаа ч цаашид улам боловсронгуй болох шаардлагатай байгаа ажээ.

Үндэстний цөөнх болон үндэстний бүс нутгийн эдийн засаг, үйлдвэр аж ахуйг түргэн хөгжүүлэх нь аливаа үндэстэн нийтээрээ цэцэглэн хөгжих явдлыг урагшлуулж буй хэрэг. Энэ бол үндэстний цөөнх болон үндэстний бүс нутгийн ард олны хүлээлгэсэн үүрэг, хариуцлага бөгөөд тиймээс ч Хятад улс үндэстний бодлогыг хэрэгжүүлж, түүний дагуу олон талын арга хэмжээ авч явуулж байна. Ялангуяа хөнгөлөлтийн бодлого хэрэгжүүлэх, хөрөнгө оруулалтын хэмжээг ихээр нэмэгдүүлэх, дэмжиж туслах, хамтарч ажиллах зэргээр үндэстний цөөнх болон тэдгээрийн газар нутгийн холбогдолтой ямар нэгэн үйл хэргийг дэмжин тэтгэж байгаа ажээ.

Үндэстний цөөнхийн боловсон хүчнийг бүхий л хүчээ дайчлан сургах нь үндэстний асуудлыг шийдвэрлэх гол зангилаа асуудал мөн хэмээн заагаад, БНХАУ байгуулагдсан цагаасаа үндэстний ажил, нийгмийн хөгжлийн зайлшгүй хэрэгцээ болж, тусгай мэргэжлийн сургуулийн боловсрол олгох, нийгмийн бодит нөхцөл байдалд тохируулан олон сувгаар үндэстний боловсон хүчнийг олноор нь сургаж ирсэн байна. Ийнхүү үндэстний цөөнхийн мэргэжилтэй боловсон хүчнийг сургаж бэлтгэснээр үндэстний цөөнхийн ажлыг

сайтар гүйцэтгэх, үндэсний эв нэгдлийг бэхжүүлэх, аливаа үйлсийг хэрэгжүүлэх баталгаа болж, хөгжлийн түлхэц тулгуур болдог байна.

Хэл, бичиг үсгийн тэгш эрх нь үндэстний тэгш эрхийн чухал үзүүлэлт, биелэлт болдог байна. Хятадын Үндсэн хууль болон үндэстний бүс нутгийн өөртөө засах дүрэмд “аливаа үндэстэн бүгд өөрийн хэл, бичиг үсгийг хөгжүүлж хэрэгжүүлнэ” гэж заасан. Үндэстний өөртөө засах орон нутагт үндэстнийхээ хэл, бичиг үсгийг өөртөө засах эрхийн дагуу хэрэглэж, үндэстэн бүр нийтээрээ өөрийн хэл, бичиг үсгийг хэрэглэн шүүхэд санал, гомдлоо мэдүүлэх эрхтэй, мөн аль ч сургуульд үндэстний хэл, бичиг үсгийг заалгахын сацуу хос хэлийг хөгжүүлж болох тухай заажээ.

Ийнхүү Хятад улсаас үндэстний цөөнхийн хэл, бичиг үсгийг хэрэглэх бодлого явуулж, үндэстэн бүрийн хэл, бичиг үсгийг өөр хоорондоо харилцан суралцах явдлыг дэмжин дэлгэрүүлж байгаа өнөө үед тухайлбал: БНХАУ-ын Үндсэн хууль, “Үндэстний бүс нутгийн өөртөө засах хууль” болон Хятадын холбогдол бүхий бусад хууль тогтоолыг үндэслэн ӨМӨЗО өөрийн тодорхой нөхцөл байдалтайгаа уялдуулан “ӨМӨЗО-ы монгол хэл, бичиг үсгийн ажлын дүрэм” боловсруулж, 2004 оны 11 дүгээр сарын 26-ны өдөр ӨМӨЗО-ы Х сонгуулийн Ардын төлөөлөгчдийн их хурлын Байнгын Хорооны 12 дугаар чуулганаар баталжээ. ӨМӨЗО-ы монгол хэл, бичиг үсгийн ажил нь нийгмийн чухал салбарын нэг, үндэстний ажлын гол бүрэлдэхүүн хэсэг, бодлогын шинж чанартай болж, нийгэм, олон нийтийн хэмжээний ажлын нэг гэх боловч үнэн хэрэгтээ явцуу хүрээнд хэрэгжиж буй. Нөгөө талаас уг ажил нь ӨЗО-д үндэстний соёл боловсролын салбарын хөгжилд ихээхэн тус нэмэр болдог байна. ӨМӨЗО-д одоогоор 4,0292 сая монгол үндэстний хүн ам 101 хошуу (сянь, хот, дүүрэг), 450 сум (сянь, суурин)-д тархан оршин сууж байгаагаас 85-аас дээш хувь нь монгол хэл, бичиг үсгээ хэрэглэдэг гэсэн мэдээлэл байна.⁴

Уламжлал, зан үйл, ёс заншил нь үндэстний онцлогийн нэг чухал агуулга бөгөөд хоол хүнс, орон байр, хувцас хунар, баяр, тэмдэглэлт өдөр, гэрлэх, оршуулах ёслол зэргээр илэрдэг байна. Үндэстний уламжлал, зан үйл, ёс заншлыг хүндэтгэх нь үндэстний тэгш эрх, эв нэгдэлд түлхэц болж үндэстэн нэг бүрийн уламжлал, соёлыг хадгалан хөгжүүлэхэд хэрэг тустай аж. Өөрчлөлт шинэчлэлийн өнөө үед Хятадын үндэстэн бүр харьцангуй нээлттэй болж өөрийн зан үйл, ёс заншлаа чөлөөтэй эдэлж хэрэглэн, хүндэтгэх болжээ. Хятад улс үндэстний цөөнх бүрийнхээ шинэ оны баяр (хаврын баяр)-ын уламжлалын дагуу амралтын өдрийг зохицуулан товлдог. Харин үндэстний цөөнхийн зан үйл, ёс заншлыг далимдуулан гарсан аливаа муу сөрөг үйлдэлд

саад хийж, таслан зогсоох зэрэг хуулийн дагуу шийдвэрлэхээр үндэстний бодлогод тусгажээ.

Хятадын засгийн газраас үндэстний цөөнхийн соёлын үйл хэргийг бүр эрт дээр үеэс чухал ач холбогдолтой хэмээн хөгжүүлж, хууль зүй, хуулийн бодлогын тухайд удаа дараа зарлиг, тогтоол батлан гаргаж, шийдвэрлэх арга хэмжээ авч явуулан, үндэстний цөөнхийн соёлын үйлсийг тал бүрээс нь дэмжин хөгжүүлснээр тодорхой амжилтанд хүрчээ. 2002 онд Төрийн Зөвлөлийн тогтоол гарч, Бүх Хятадын үндэстний цөөнхийн соёл урлагийн их наадмыг 5 жилд 1 удаа зохион байгуулахаар шийдвэрлэжээ.⁵ Их наадмын тоглолт үзүүлбэр бүхэн үндэстний онцлог, нутаг орны онцлог, цаг үеийн онцлогийг харуулдаг болохоор үндэстний цөөнхийн ард түмэн маш идэвхтэй бэлтгэн оролцдог байна.

Өнгөрсөн арав гаруй жилд Хятадын цөөнх үндэстний бүс нутгийн эдийн засгийн хөгжил, шинжлэх ухаан, соёл, боловсролын үйл ажиллагаа эрчимжиж, үндэстний хүн амын эрүүл мэнд, төлөвлөгөөт төрөлтийн ажил тодорхой дэвшилд хүрч байна. Үндэстний цөөнх болон үндэстний бүс нутгийн хүн амын бодит өсөлтөнд хяналт тавьснаар зарим үндэстний цөөнх болон үндэстний бүс нутагт төрөлт ихсэж, нас баралт буурч, хүн амын нөхөн үржихүйн хэлбэр аргад ахиц гарч байна. Улмаар үндэстний хүн амын бодгаль шинж, төрөх насны нийт эмэгтэйчүүдийн нөхөн үржихүйн эрүүл мэндийн төвшин харьцангуй дээшилж, тодорхой өөрчлөлт дэвшил гарсаар байна. Хятад улс 2010 он хүртэл үндэстний бүс нутгийн төлөвлөгөөт төрөлтийн ажилд шинэ зорилтууд дэвшүүлээд байна.

Шашин шүтлэг үндэстний цөөнхийн дунд маш их нөлөөтэй бөгөөд үндэстний асуудал, шашин шүтлэгийн асуудал ямагт хамт байдаг. Хятад улс сүсэг бишрэлийг дураар нь чөлөөтэй тавьж, шашин шүтэх эс шүтэх нь тухайн газар нутагт тэгш эрхтэй хэмээн үндэстний бодлогод заасан. Харин улс нийгмээрээ хүлээн авах боломжгүй хүмүүнлэгийн нийгэмд харш, янз бүрийн гаж, хатуу дэг жаягтай ямарваа нэг шашны урсгал, шашны номлол шүтлэгийг таягдан хаях болно. Шашны элдэв сөрөг хөдөлгөөнд хатуу хяналт тавьж, хууль зүйн дагуу шашны үйл ажиллагааг удирдан явуулах болно гэж заасан байна.

Хятад улс дээрхи хэдэн зүйлийг үндэслэсэн үндэстнийхээ бодлогыг хэрэгжүүлэхийн төлөө бодитой үйл ажиллагаа явуулж байгаа. Гэвч үндэстний бодлогын хэрэгжилт нь төлөвлөгөөт эдийн засгийн хэлбэрээр, социалист зах зээлийн эдийн засгийг бүтээн байгуулах явцад тодорхой бодлогод маш их өөрчлөлт гарч, зөрчилдөн үр өгөөжгүй, ашиггүй зүйл нэлээд гарах болжээ. Иймээс урьдчилан сэргийлэх арга

хэмжээ авахын тулд үнэн бодит судалгаа хийж, зах зээлийн эдийн засгийн нөхцөл байдалд зохицуулан үндэстнийхээ ажлыг шинээр нэмж засварлан үргэлжлүүлж, үндэстний бодлогыг үр дүнтэй хэрэгжүүлэх асуудлыг чухалчилж байна⁶ гэж БНХАУ-ын Улсын Үндэстний хэрэг эрхлэх хорооноос мэдээлжээ.

ЭШЛЭЛ ЗҮҮЛТ

1. Хятадын үндэстний бодлого. <http://www.seac.gov.cn/content/cm/cmapp/bulletincontentview.06.11.13>
2. Мөн тэнд.
3. <http://www.xinhuanet.com/zhibo/20050228/tp.htm>
4. “Солонго” сэтгүүл. 2005.№2(128) т.16-17
5. <http://www.seac.gov.cn/wyhy/mzwhbhfz/2006.09.21/1158798284574520.htm>.
6. БНХАУ-ын Улсын Үндэстний хэрэг эрхлэх хороо. <http://www.seac.gov.cn/content/cm/cmapp/bulletincontentview>.